

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Цахилгаан, шугам сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/01/-НА-СТА-ТБОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: У.Ербол
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллагын үйл ажилагаа	12
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13
4. Аудитын тайлан	12
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Дотоод хяналт	16
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
4.4 Материаллаг байдал	16
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
5.1 Шилэн дансны мэдээлэл	17
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
8. Аудитын илрүүлэлт	18
8.1 Залруулсан алдаа	18
8.2 Төлбөрийн акт	18
8.3 Албан шаардлага	18
8.4 Зөвлөмж	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Аудитын санал дүгнэлт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Ж.КЕРЕЙ ТАНАА

᠒᠐22.03.15 № 31᠖
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Цахилгаан шугам сүлжээний газар нь санхүүгийн тайлангаа Сангийн сайдын баталсан заавар аргачлалын дагуу бэлтгэсэн бөгөөд санхүүгийн тайланд холбогдох мэдээллийг бүрэн толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Аудитын хамрах хүрээний хязгаарлалттай холбоотой хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРС  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	460,279,833.78	715,474,512.25
1.1.2	Дансны авлага	1,699,070,597.28	547,058,486.07
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	33,875,648.75	208,363,412.85
1.1.4	Бусад авлага	45,556,730.00	623,448,592.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	124,440,357.10	233,485,273.10
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,363,223,166.91	2,327,830,276.27
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,862,467,956.97	8,094,289,902.61
1.2.2	Биет бус хөрөнгө	130,476,800.00	130,476,800.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,992,944,756.97	8,224,766,702.61
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,356,167,923.88	10,552,596,978.88
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	148,313,815.27	79,533,139.52
2.1.1.2	Цалингийн өглөг	0.31	
2.1.1.3	Татварын өр	10,116,457.56	
2.1.1.4	НДШ -ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	435,410,000.00	
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	593,840,273.14	79,533,139.52

Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	2,136,587,736.70	2,136,587,736.70
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,136,587,736.70	2,136,587,736.70
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,730,428,009.84	2,216,120,876.22
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	10,698,433,754.84	10,698,433,754.84
2.3.2	· хувийн		
2.3.3	· хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	480,277,808.77	480,277,808.77
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		927,172,584.91
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(3,552,971,649.57)	(3,769,408,045.86)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,625,739,914.04	8,336,476,102.66
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	10,356,167,923.88	10,552,596,978.88

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	9,233,446,908.16	10,489,796,933.51
2	Борлуулалтын өртөг	6,621,418,635.50	7,444,207,731.60
3	Нийт ашиг(алдагдал)	2,612,028,272.66	3,045,589,201.91
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	19,284,948.53	6,945,853.30
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	51,968,090.85	60,055,459.56
9	Борлуулалт, маркетингийн зардал	20,478,295.00	24,786,929.24
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,587,112,895.13	1,652,007,327.06
11	Санхүүгийн зардал	1,296,697,381.51	1,437,870,542.74
12	Бусад зардал	37,045,539.97	27,327,473.78
13	Гадаад валютын ханшийн зөрүүнийолз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	(68,543,968.35)	(186,340,052.99)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(326,596,767.92)	(215,741,811.04)
19	Орлогын татварын зардал	1,928,494.85	694,585.33
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(328,525,262.77)	(216,436,396.37)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(328,525,262.77)	(216,436,396.37)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютынхөрвүүлэлтийн зөрүү		
	Бусадолз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(328,525,262.77)	(216,436,396.37)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	7,878,069,649.00	172,592,692.77	3,281,849,222.00	(3,378,620,001.52)	7,953,891,562.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				154,173,614.84	154,173,614.84
3	Залруулсан үлдэгдэл	7,878,069,649.00	172,592,692.77	3,281,849,222.00	(3,224,446,386.68)	8,108,065,177.09
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				(328,525,262.77)	(328,525,262.77)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт	2,820,364,105.84		(3,281,849,222.00)		(461,485,116.16)
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		307,685,116.00			307,685,116.00
9	2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77		(3,552,971,649.45)	7,625,739,914.16
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(0.04)	(0.04)
11	Залруулсан үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77		(3,552,971,649.49)	7,625,739,914.12
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(216,436,396.37)	(216,436,396.37)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт			927,172,584.91		927,172,584.91
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77	927,172,584.91	(3,769,408,045.86)	8,336,476,102.66

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйлажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,483,822,310.99	9,538,403,828.08
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,361,531,448.32	3,363,530,785.32
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	43,162,349.45	47,574,226.19
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	898,850.00	
	Буцаан авсан албан татвар	913,191.00	
	Татаас, санхүүжилтийн орлого	20,671,400.00	5,874,287,033.26
	Бусад мөнгөн орлого	1,056,645,072.22	253,011,783.31
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,015,165,005.32	3,562,209,149.61
	Ажиллагчдад төлсөн	1,084,032,384.63	1,144,867,411.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	354,957,279.32	382,218,821.73
	Бараа материал худалдан авахад төлсөн	309,597,740.00	423,851,293.00
	Ашиглалтын зардалд төлсөн	733,730.00	10,015,482.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	164,505,165.00	229,781,898.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	396,567,413.94	602,716,814.63
	Даатгалын төлбөрт төлсөн	10,586,965.44	24,754,692.43
	Бусад мөнгөн зарлага	694,184,326.99	744,002,736.82
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,468,657,305.67	5,976,194,678.47
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,565,000,000.00	5,721,000,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	4,565,000,000.00	5,721,000,000.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		

Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3	Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,565,000,000.00)	(5,721,000,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааныцэвэр мөнгөн гүйлгээнийдүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(96,342,694.33)	255,194,678.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	556,622,528.11	460,279,833.78
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	460,279,833.78	715,474,512.25

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт		9,233,446,900.00	10,345,613,800.00	10,489,796,933.51	(144,183,133.51)	101.4
	Үйлдвэрлэлийн байгууллага	сая.төг	2,326,000,000.00	2,127,300,000.00	2,140,200,000.00	(12,900,000.00)	100.6
	Худалдаа үйчилгээний байгууллага	сая.төг	1,134,200,000.00	1,128,500,000.00	1,272,600,000.00	(144,100,000.00)	112.8
	Төсөвт байгууллага	сая.төг	1,195,700,000.00	2,167,923,800.00	2,150,000,000.00	17,923,800.00	99.2
	Орон сууц	сая.төг	370,946,900.00	594,300,000.00	592,900,000.00	1,400,000.00	99.8
	Гэр хороолол	сая.төг	1,896,600,000.00	1,895,450,000.00	1,902,600,000.00	(7,150,000.00)	100.4
	Сумдууд	сая.төг	2,310,000,000.00	2,432,140,000.00	2,431,496,933.51	643,066.49	100.0
2	Нийт орлого		9,304,699,939.38	10,413,113,800.00	10,556,798,246.37	(143,684,446.37)	101.4
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	9,233,446,900.00	10,345,613,800.00	10,489,796,933.51	(144,183,133.51)	101.4
	Хүүгийн орлого	сая.төг	19,284,948.53	7,850,000.00	6,945,853.30	904,146.70	88.5
	Бусад орлого	сая.төг	51,968,090.85	59,650,000.00	60,055,459.56	(405,459.56)	100.7
3	Нийт зардал		9,633,225,202.15	10,670,542,300.00	10,773,234,642.74	(102,692,342.74)	101.0
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	6,621,418,635.00	7,129,899,100.00	7,444,207,731.60	(314,308,631.60)	104.4
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	1,587,112,867.15	1,550,500,500.00	1,652,007,327.06	(101,506,827.06)	106.5
	в) Хөрөнгө оруулалт их засвар	сая.төг	78,854,500.00	432,082,800.00	187,202,700.00	244,880,100.00	43.3
	г) элэгдлийн зардал	сая.төг	944,209,100.00	884,979,300.00	876,015,100.00	8,964,200.00	99.0
	д) Орлогын албан татвараас бусад татвар	сая.төг	7,974,900.00	28,500,000.00	34,479,400.00	(5,979,400.00)	121.0
	е) Үйл ажиллагааны зардал	сая.төг	393,655,200.00	644,580,600.00	579,322,384.08	65,258,215.92	89.9
4	Цэвэр ашиг, алдагдал		(328,525,262.77)	(257,428,500.00)	(216,436,396.37)	(40,992,103.63)	84.1

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрын зорилго нь дэвшилтэт технологийг нэвтрүүлэн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай түгээн, хангаж хэрэглэгчдээ дээдлэн ажиллах. хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд мөрдөж, санхүү эдийн засгийн хүрээнд үр бүтээлтэй ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа явуулна гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай ба өмчийн 100 хувь нь орон нутгийн эзэмшилд байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Цахилгаан шугам сүлжээний газар нь 1999 онд анх Дэд бүтцийн яамны шийдвэрийг үндэслэн байгуулагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 101 дугаар тогтоолоор шинэчлэн томилсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2-ийн 2, болон 3 дахь хэсэгт нийцсэн байна.

Цахилгаан шугам сүлжээний газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг Цахилгаан шугам, сүлжээний газрын Удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж гишүүн бүрт сарын 250.0 мянга, жилийн 15.0 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд тус байгууллагаас тодорхой арга хэмжээ авч ажилласан зүйл байхгүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл

ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцэд ороогүй, тайлант онд орон тоо нэмээгүй байна. Цалингийн зардлыг өмнөх оноос 20.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх тухай шийдвэрлэсэн байна. Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоолоор дээрх шийдвэрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлсэн Сангийн сайдын тушаалаар баталсан заавар аргачлалын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	460279.8	715474.5	255194.7
БХХО			
Авллага	1778502.9	1378870.5	-399632.4
Урьдчилгаа			
Бараа материал	124440.4	233485.3	109044.9
Үндсэн хөрөнгө	7862467.9	8094289.9	231822.0
Биет бус хөрөнгө	130476.8	130476.8	0
Нийт хөрөнгийн дүн	10356167.9	10552596.9	196429.0
Өр төлбөрийн дүн			
Богино хугацаат өглөг	593840.3	79533.1	-514307.2
Урт хугацаат өглөг	2136587.7	2136587.7	0.0
Эздийн өмч	7625739.9	8336476.1	710736.2

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10356167.9	10552596.9	196429.0
---	-------------------	-------------------	-----------------

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 0.2 сая төгрөгийн, банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 715.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэлд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын авлага 10.0 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 171.6.сая төгрөг, бусад авлага 26.7 сая төгрөгийг эзэлж байна.

Жилийн эцэст нийт 1378.8 сая төгрөгийн авлагатай гарсан ба үүний 208.4 сая төгрөгийн авлага нь дээрх татвар, НДШ-ийн авлага, 547.0 сая төгрөгийн авлага нь дансны авлага / айл өрх, орон сууц, төсвийн байгууллага, ААНБ-ын цахилгааны авлага/ , 623.4 сая төгрөгийн авлага нь бусад авлага /“Эрдэнэт” ТӨХК-аас авах авлага 579.2 сая, бусад авлага 44.2 сая төгрөг/ байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 1352.8 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 26.0 сая төгрөгийн найдваргүй авлага байна.

Тайлант онд 45.5 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, Удирдах зөвлөлийн 02 дугаар тогтоолоор 19.5 сая төгрөгийн найдваргүй авлагыг данснаас хассан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 233.5 сая төгрөг болж 109.0 сая төгрөгөөр өссөн нь бараа материалын өсөлтөд нөлөөлжээ.

Тайлант оны эхэнд 124.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан ба 643.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч 534.4 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 233.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь сэлбэг хэрэгсэл худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд шинээр 12.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1087.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр тус тус нэмэгдэж, аймгийн ИТХ-Тэргүүлэгчдийн 2021 оны 133 дугаар тогтоолоор 129.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд 130.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 79.5 сая төгрөгийн өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2011 онд Дэлхийн банкны төслийн шугамаар авсан 2136.6 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өр төлбөр байгаа ба ямарч төлөлт хийгдээгүй үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Өмнөх онтой харьцуулахад нийт зардал 1140.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цахилгааны хэрэглээ, тээвэр шатахуун, сэлбэг материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Цахилгаан шугам сүлжээний газар нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Цахилгаан шугам сүлжээний газрын Удирдах зөвлөлийн 2021 оны 01 дугаар тогтоолоор “Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 10413.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 10670.5 сая төгрөгөөр, 257.4 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 10556.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 10773.2 сая төгрөгийн зардал гарган, 216.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 10556.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 143.7 сая төгрөг буюу 1.4 хувиар давсан нь цахилгааны хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 10773.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 102.7 сая төгрөг буюу 0.9 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь мөн адил цахилгааны хэрэглээ нэмэгдсэн, шатахуун, сэлбэг материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд 216.4 сая төгрөгийн цэвэр алдагдалтай гарж төлөвлөснөөс 40.9 сая төгрөгөөр алдагдлаа бууруулсан нь орлого давуулан биелүүлсэн, техникийн алдагдлыг бууруулж ажилласан нь нөлөөлсөн байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баян-Өлгий аймгийн Цахилгаан, шугам сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Цахилгаан, шугам сүлжээний газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитаас өмнөх оны санхүүгийн баримтуудад хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Цахилгаан, шугам сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт хөрөнгийн 105.5 сая төгрөгөөс 70 хувиар буюу 83.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цахилгаан, шугам сүлжээний газар нь тайлант онд нийт 10773.2 мянган төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас авлага, өглөг үүсгэсэн шийдвэрийн талаарх 3594.9 сая төгрөгийн 8 мэдээлэл, бусад мэдээллээс 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой зөрчилд өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан засварын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5083.7 сая төгрөгийн зөрчлийн 3.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 4578.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 501.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс акт 100 хувь, албан шаардлага 70.1 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3.6	1	3.6	0	0	100
Албан шаардлага	2	4578.7	2	3205.1	2	1373.6	70.1
Зөвлөмж	2	501.4	2	501.4	0	0	100
Нийт дүн	5	5083.7	5	3710.1	2	1373.6	90

Цахилгаан, шугам сүлжээний газрын өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалттай байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Цахилгаан, шугам сүлжээний газрын санхүүгийн тайлангийн орлого, заодал, үлдэгдэлийг түүвэрлэн шалгаж дүгнэлт гаргасан тул гүйцэтгэлийн аудитаар өмч хөрөнгийн бүртгэл, зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3594.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3594.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөрчилд албан шаардлага өгсөн.

Залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй ба тогтоосон материаллаг 83.4 сая төгрөгийн түвшингээс бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Байхгүй

8.2 Төлбөрийн акт

Байхгүй

8.3 Албан шаардлага

Аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 3594.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

10773.2 мянган төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас авлага, өглөг үүсгэсэн шийдвэрийн талаарх 3594.9 сая төгрөгийн 8 мэдээлэл, бусад мэдээллээс 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, 6.1.6 дах заалт, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

